

**СЭДЭГЧ БА ТИЙН ЯЛГАЛЫГ ОРЧИН ЦАГИЙН ТҮРЭГ МОНГОЛ ХЭЛНИЙ
ЖИШЭЭГЭЭР ХАРЬЦУУЛАХ НЬ**

М. Ууганбаяр*

Уламжлалт хэл шинжлэлд үгийн өгүүлбэр дэх үүргийн хэлбэржилтийг тийн ялгал хэмээн тооцоод заахын тийн ялгал нь шууд тусагдахуун, гарахын тийн ялгал, өгөх оршихын тийн ялгал нь шууд бус тусагдахуун, нэрлэхийн тийн ялгал нь өгүүлэгдэхүүн, харьяалахын тийн ялгал нь тодотгол гэсэн өгүүлбэрийн гишүүний үүрэгтэй гэхчлэн авч үздэг. Гэтэл түгээмэл хэл зүйн үүднээс тийн ялгалыг судлахад нэрийн хэлхцийн үг зүйн дүр төрх, хэлхцийн бүтцийн байрлалын харилцан нөлөөлөл чухал байдаг. (Үзүн 2000:190) Чомски, тийн ялгалын онол нь хийсвэр тийн ялгалын оноолт тэдний үгзүйн хэрэгжилттэй холбоотой (Чомски 1981:6) гэсэн ба тийн ялгал нь тийн ялгал оноогчоор бүхий л нэрийн хэлхцэнд оноогдоно (Күүк 1988:143). Үүнээс үүдээд тийн ялгалыг үг зүйн дүр төрхөөс үл хамаарсан хийсвэр тийн ялгал буюу нэрлэхийн тийн ялгал, үг зүйн хувьд ил тод буюу үг зүйн тийн ялгал орших, гарах, чиглэх гэж үзнэ. Түгээмэл хэл зүйд үйл үгийн сэдвийн харьцаа буюу сэдэгчээс үл хамаарах бүтцийн тийн ялгал, нэрийн хэлхцэнд үйл үгийн оноох сэдэгчийн байрлалтай холбоо бүхий дотоод тийн ялгал өөрөөр хэлбэл өнгөн ба гүн бүтцийн тийн ялгал зэрэг ойлголт чухалд тооцогддог.

Бид энэ удаа орчин цагийн түрэг монгол хэлний зарим тийн ялгалын утгыг сэдэгчийн үүднээс өөрөөр хэлбэл үйл үгийн үндэслэгчтэйгээ харьцах утга зүйн харьцаа, үйл үгийн сэдвийн харьцааны талаас тодруулан үзэхийг зорьж байна. Үйл үгийн үгийн сангийн бүрэлдэхүүнд сэдэгч чухал байртай байдаг.

Түгээмэл хэл зүйд Грүбер (1965), Филлмор (1968), Жакендофф (1972) нарын судалгаагаар тухайн өгүүлэгдэхүүний үндэслэгч бүр (argument of predicate) (субъект нөхөгч), (subject and complement) тусгай сэдвийн үүргийг (Theta role, thematic roles) өөрөөр хэлбэл сэдэгчийг тээх ба үндэслэгчийг гүйцээж болох сэдвийн үүрэг нь ихэд хязгаарлагдсан төгсгөлөг түгээмэл дүрмээс сурвалжтай байдаг. Судлаачдын нийтээр зөвшөөрдөг сэдэгч буюу сэдвийн үүргийг жагсаавал

THEME or PATIENT эдлэх сэдэгч. Зарим нэг үйлийн үр дүнд өртөгч. Энэ нэр томъёог М. Базаррагчаа монгол хэлнээ эдлэн үйлдэгч хэмээн орчуулжээ. (2005:84)

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургууль.

Mary fell over

Мэри тээглэж унав

AGENT or ACTOR үйлдэх сэдэгч. Зарим нэг үйлийг эхлүүлэгч. Энэ нэр томъёог М.Базаррагчаа монгол хэлнээ идэвхтэй үйлдэгч эзэн хэмээн орчуулжээ (Базаррагчаа 1987:295)

John killed Harry

Жон Хэрриг алав

EXPERIENCER турших сэдэгч. Зарим нэг сэтгэлзүйн байдлыг туршин эдлэгч ахуй. Энэ нэр томъёог М.Базаррагчаа монгол хэлнээ үйл эдлэгч эзэн хэмээн орчуулжээ. (Базаррагчаа 1987:295)

John was happy

Жон жаргалтай байв.

BENEFACTIVE хүлээх сэдэгч. Зарим нэг үйлийн ашгийг хүртэгч ахуй. Энэ нэр томъёог М.Базаррагчаа монгол хэлнээ үйл хүлээгч эзэн хэмээн орчуулжээ (Базаррагчаа 1987:295)

John bought some flowers for Mary

Жон Мэрид хэдэн цэцэг худалдан авав

INSTRUMENT хэрэгсэх сэдэгч. Зарим нэг зүйл хийх хэрэгсэл. Энэ нэр томъёог М. Базаррагчаа монгол хэлнээ зэвсэг хэрэглүүр хэмээн орчуулжээ. (Базаррагчаа 2005:84)

John wounded Harry with a knife

Жон Хэрриг хумгаар шархдуулав.

LOCATIVE орших сэдэгч. Зарим нэг зүйл оршин байх газар орон. Энэ нэр томъёог М. Базаррагчаа монгол хэлнээ орон хэмээн орчуулжээ. (Базаррагчаа 2005:84)

John hid the letter under the bed

Жон захиаг орон доор нуув.

GOAL зорих сэдэгч. Зарим нэгэн зүйл чиглэх хөдлөх ахуй. Энэ нэр томъёог М. Базаррагчаа монгол хэлнээ зорилго хэмээн орчуулжээ. (Базаррагчаа 2005:84)

John passed the book to Mary

Жон Мэрид ном дамжуулав.

SOURCE үүсэх сэдэгч. Зарим нэг зүйл хөдлөн гарах ахуй. Энэ нэр томъёог М. Базаррагчаа монгол хэлнээ үүсвэр хэмээн орчуулжээ. (Базаррагчаа 2005:84)

John returned from Paris

Жон Парисаас буцаж ирэв.

(Radford 1988:373)

Дээрх жишээнээс харвал Жон нь өгөх гэсэн үйл үгийн үйлдэх сэдвийн үүргийг тээх ба Мэри нь зорих үүргийг, ном нь сэдэх үүргийг агуулж байна.

Шархдуулах гэсэн үйл үгэнд шархдагч, шархдуулагч гэсэн хоёр сэдэгч утга зүйн үүднээс зайлшгүй шаардлагатай бол унтах гэсэн үйл үгэнд унтагч гэсэн сэдэгч хэрэгтэй болдог. Олон үйл үг дундын сэдэгчтэй байж болдог. Тухайлбал, *хэрчих, эвдэх, өрөх* гэх мэт үйл үгэнд үйлдэх сэдэгч буюу үйл хөдлөлийг үйлдэж байгаа эзэн нь нэг юм. Өөрөөр хэлбэл *хэрчигч, эвдэгч, өрөгч* гэсэн нэг сэдэгч болно. Гэтэл *алхах, гүйх, харайх, ханиах* гэх мэт үйл үг болбол үйлийг үйлдэж байгаа субъект нь үйлийнхээ нөлөөнд орж байгаа учир туршин сэдэгч болж байна.

Н. Э. Үзүний үзүүлсэн

Ali cocuga kitabi verdi

Али хүүхдэд ном өгөв.

гэсэн орчин цагийн түрэг хэлний жишээнд хүүхэд гэдэг нэр үг сэдэгчийг оноож байгаа үйл үгийн сэдвийн харьцаа буюу чиглэлийн талаасаа зорих сэдэгч, үйл үгийн үр дүнгийн талаасаа ашиглах сэдэгч болно.

Бид Н. Э. Үзүний дурдсан бас нэг баримтыг ялимгүй өөрчлөн дэлгэрүүлж

Хүүхэд хана мөргөв.

Хүүхэд хананд мөргөв.

Хүүхэд ханаруу мөргөв.

гэх гурван өгүүлбэрийг зохион харахад *хана мөргөнө* гэсэн нэг үйлдэл гурван өөр тийн ялгалаар илэрч байгаа шалтгаан нь тийн ялгалыг оноох үйл үгийн сэдэгчийн утга билээ. Жишээлбэл:

Хүүхэд хана мөргөв.

хэмээх өгүүлбэрт хана гэсэн нэр үг заахын тийн ялгалаар хэлбэржсэн шалтгаан нь хана-өртөх сэдэгч, хүүхэд-үйлдэх сэдэгч болох бөгөөд

Хүүхэд хананд мөргөв.

хэмээх өгүүлбэрт хана-өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржиж байгаа шалтгаан нь хүүхэд-турших сэдэгчийн утгыг зааж, хана-байрших сэдэгч гэдгээс

Хүүхэд ханаруу мөргөв.

гэх өгүүлбэрт хана гэдэг үг үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржиж байгаа шалтгаан нь хана-зорих сэдэгч, хүүхэд-үйлдэх сэдэгч болж буйгаас үүдэх болно.

Орчин цагийн түрэг монгол хэлний нэрийн тийн ялгалын нөхцлийн бие биеэ орлох буюу солих найруулах онцлогийн судалгаа ч бидний дээр дурдаж буй жишээтэй холбоотой юм. А. Бүрэн, (1996), Т. А. Бертагаев (1964), М. Базаррагчаа (1987, 2005).

А. Бүрэн түрэг хэлний орших тийн ялгалын нөхцөл заахын тийн ялгалыг орлон хэрэглэгдэх тухайд,

Almis onu da dislemis

Аваад түүнд ч /түүнийг ч нэг зуужээ. (1996: 127, 200)

М.Базаррагчаа монгол хэлний өгөх оршихын тийн ялгалын нөхцөл заахын тийн ялгалын нөхцлөөр солигдох тухайд,

Өрөвчхөн сэтгэлтэй их буянтай хүн, ногоон дарь эхйн бүрэлбаа ч байж юу магад гэж ахайданд/ахитныг сүсэглэн, минь бодож явсан маань дэмий биш байлтай (Ж.П)

заахын тийн ялгалын нөхцөл өгөх оршихийн тийн ялгалын нөхцлөөр солигдохын тухайд

Цацаг мөнгөн Буйрыг /Буйрт хүрнээ гэж тэд санажээ.

Өгөх оршихын тийн ялгалын нөхцөл чиглэхийн нөхцлөөр солигдох тухайд

Алтай уулын бэлд бэл рүү аялж очлоо би (Т.Г)

Хүргэн Балдан хуучин сумын занги байсан Намжидлиийнд зарагддаг тул тэдний өрх малын хамт холын хошуунд/хошуу руу оторлон оджээ (Базаррагчаа 2005:147)

гэх баримтыг тус тус дурдсан байна

Н.Э. Үзүн орчин цагийн түрэг хэлний

Ali Istanbuldan ayrildi

Али Стамбулаас гарав.

Ali Istanbuldan gecti

Али Стамбулаас өнгөрөв (2000:107)

гэх жишээнээс эхний өгүүлбэрийн Стамбулаас гэсэн махбод үүсэх сэдэгчийн үүргийг харин дарах өгүлбэрийн Стамбулаас нь орших сэдэгчийн үүргийг хүлээж буйг дурджээ. 3. Коркмаз ч орчин цагийн түрэг хэлэнд гарахын тийн ялгал болохуй ба үйлдэхүйн гарах цэг хөдлөлийн эхлэлийг мөн орон чигийг заадаг гэж бичсэн байна (Коркмаз 2009:301-307)

Мөн Н. Э. Үзүний гаргасан

Ali cocuga cicek yolladi

Али ээждээ цэцэг илгээв.

Ali cocuga cicek topladi

Али ээждээ цэцэг түүв. (2000:107)

гэсэн хоёр өгүүлбэрийн ээждээ гэсэн махбод өнгөн бүтцийн үүднээс харахад хоёулаа нэгэн адилаар өгөх оршихын тийн ялгалаар хувилсан боловч гүн бүтэцдээ буюу сэдэгчийн үүднээс хоёр өөр утгатай байх ба *Али ээждээ цэцэг илгээв* гэсэн өгүүлбэрийн ээждээ гэсэн махбод зорих сэдэгчийн утгатай бол *Али ээждээ цэцэг түүв* гэсэн өгүүлбэрийн ээждээ гэсэн махбод ашиглах сэдэгчийн утга агуулж байна.

Энд мөн л *илгээх*, *түүх* хэмээх үйл үгийн утга зүйн онцлог, сэдвийн онцлог, сэдэгчийн оноолт нөлөө үзүүлж байгааг ажиглан харж болно. Өөрөөр хэлбэл ээждээ гэсэн хоёр үг нь өнгөн бүтцийн тийн ялгалын хувьд адилхан, гүн бүтцийн буюу дотоод тийн ялгалын үүднээс хоёр өөр байна.

Дээрх лүгээ төстэй жишээг монгол хэлнээс гарган үзвэл,

Галт тэрэг Улаанбаатараас өнгөрөв.

Галт тэрэг Улаанбаатараар өнгөрөв.

гэсэн хоёр ойролцоо өгүүлбэр нэг тийн ялгалаар хэлбэржсэн хэрнээ утгын хувьд ялгаатай байгааг зөвхөн сэдэгчийн талаас л тодруулж болж байгааг тайлбарлах ёстой.

Гарах гэдэг үйл үгийн оноох сэдэгч нь эхний өгүүлбэрт *Улаанбаатараар* гэсэн үгийг “*гарах сэдэгчийн*” утгатай болгож харин хоёрдугаар өгүүлбэр нь байрших сэдэгчийн утга агуулж байна.

Үүнтэй адил баримтыг түрэг болоод монгол хэл судлаачид ч дурджээ (Бүрэн 1996:233, Базаррагчаа 2005:149)

Түр.

Bir erden/erde bir avrat varmis

Нэг эрээс/ нэг эрд нэг эхнэр байжээ

Evden/evde asiliydi et cengeli

Гэрээс гэрт махны дэгээ өлгөөтэй байв

Монг. *Цаад айл амьтнаар /айл амьтнаас сураглахгүй юу (Ш. Г)*

Зуун бээрээр зуун бээрээс дуниартсан зуны тал униартана (Д.П)

Ер хүн амьдралдаа эх шигшээ тийм уян хатан сэтгэлээр уян хатан сэтгэлээс хайрлан энхрийлдэг хүнийг хэзээ ч хаанаас ч олж чадахгүй биз ээ (З. С)

Ийнхүү орчин цагийн түрэг, монгол хэлний тийн ялгалын утга, үүрэг, хувилбарыг таньж мэдэхэд тийн ялгалыг гүн бүтцийн талаас судлах хэрэгтэй ба тийн ялгалын утгад үйл үгийн утгазүй, сэдвийн онцлог, сэдэгчийн оноолт нөлөөлдөг байна.

SUMMARY

In this brief article author discusses in the frame of the theory of Universal Grammar about the connection of the thematic roles or theta roles and deep cases in modern Turkish and Mongolian. Author also compares Turkish and Mongolian facts from various investigations and diverse point of views.

НОМ ЗҮЙ

- Базаррагчаа М., *Монгол хэлний өгүүлбэр*, Улаанбаатар, 1987
Базаррагчаа М., *Монгол хэлний өгүүлбэр судлал*, Улаанбаатар, 2005
Бертагаев Т. А., *Синтаксис современного монгольского языка в сравнительном освещении. Простое предложение*, Наука, М., 1964
Кузьменков Е. А., *Глагол в монгольском языке*, Изд., Ленинградского университета. Л., 1984
Buran A *Anadolu Agizlarinda Isim Cekim /Hal/ Ekleri*, Ankara, 1996
Chomsky N., *Lectures on Government and Binding*, Foris, Dordrecht, 1981
Cook V. J., *Chomsky's Universal Grammar. An Introduction*. Basil Blackwell. 1988
Gruber, J. S., *Studies in Lexical Relations*, PhD dissertation, MIT, Cambridge, Mass. 1965
Fillmore C. J., *Lexical Entries for Verbs Foundations of Language*, 4, 1968
Haegeman L. *Introduction to Government and Binding theory*. Blackwell, 1994
Jackendoff R. S., *Semantic Interpretation in Generative Grammar*, *Semantic Interpretation*, MIT, Cambridge, Mass. 1972
Korkmaz Z., *Turkiye Turkcesi Grameri Sekil Bilgisi*, Ankara, 2009
Radford A., *Transformational Grammar: A First Course*, Cambridge, 1988
Uzun N. E., *Anacizgileriyle Evrensel Dilbilgisi ve Turkce*. Multilingual, Istanbul, 2000